

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2023.08.31

Хавирга

**Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:**

**Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хуралдаж 2023 оны төсөвт өөрчлөлт оруулсан. Уг хурлаар “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г гүйцэтгэгч “Газар дэлхий” ХХК тайлан тавьж Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлав.

Байгууллагын удирдлагуудын хурлыг зохион байгуулж, бодлого шийдвэрийг хүргэн, өвөлжилтийн бэлтгэл ажил, бүтээн байгуулалтын ажлын явцыг хэлэлцэж, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудын чиглэлийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгөв.

**Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:**

2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, 2024 оны төсвийн төсөөллийг Аймгийн төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан.

2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг ажлын хэсэгт танилцуулж, үнэлгээ хийлгүүлсэн.

**Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:**

Байгууллагын удирдлагууд, тамгын газрын мэргэжилтнүүдтэй хамтран хууль эрх зүйн чиглэрээр ажиллах төлөвлөгөөг баталсан.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд сумын төвийн 4 дүгээр баг сонгогдон түүврийн анхан шатны нэгжид 200 өрхийн хаягийн мэдээллийг тодруулах ажлын явц 75 хувьтай 08.25-09.05-ны өдрийн дотор хийгдэж дуусахаар төлөвлөгдсөн. Мөн “Хүн ам өрхийн мэдээллийн сангийн баяжилтын ажил” тус баг дээр хийгдэж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нар сумын ЭМТ-д ирж дотор, эмэгтэйчүүд, рентген, шинжилгээ-оношилгоо, сүрьеэгийн үзлэгийг нийт 143 хүнд хийсэн.

Алтан дарь овооны тэнгэрийг тайх төрийн их тахилга 110 жилийн ойн баяр наадмын үеэр Дарьганга өв соёлын үзэсгэлэнг 2023.08.04-06ны өдрүүдэд зохион байгуулж ард иргэдийн гар дээрх болон орон нутаг судлах танхимын 85 ширхэг үзмэрийг дэлгэж 2386 хүнд үйлчилсэн.



"НҮҮДЭЛЧИН" ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ"-д сумаа төлөөлөн уламжлалт суран эдлэл, мал аж ахуйн тоног хэрэглэл бэлтгэн өв тээгч нэг иргэн оролцсон.



**Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:**

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 4 ширхэг нөлөөлөх самбрыг сумын төв хэсэг болон ногоон байгууламжийн хэсэгт байршуулсан.





Сумын төвийн хэсгийн ногоон байгууламж болон баруун хойд хэсэгт байрлах ногоон байгууламжийг 7 хоногийн 1 өдөр усны машинаар /8тонн/ 5 удаагийн давтамжтайгаар усалгаа хийдэг.



Сумын засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/82 тоот захирамжаар цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга 61 өрхийн 11,100 хурга таригдаж, тарилгын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Сумын засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/80 тоот захирамжаар угаалгын ажил эхэлж, 30 өрхийн 21,200 хонь, 5200 ямаа нийт 26,400 мал угаагдаж мал угаалгын ажил хийгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБС, 2-р багийн Мэндийн ухаа хэмээх газарт гүний худаг гарган үүнийг Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас ажлын хэсэг ирэн хүлээн авсан.

### **Зургаа.Бүтээн байгуулалтын ажлын чиглэлээр:**

Орон нутгийн хөгжлийн сангийн 300,000,000 төгрөгөөр хийгдэх “Уурын зуухны шинэчлэл” ажил хийгдэж дууссан. Гүйцэтгэгч компани 09 сарын 15-нд 72 цагийн галлагаа хийгдсэний дараагаар хүлээлгэж өгнө.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 96,757,000 төгрөгөөр хийгдэх “Багийн төвийг нүүлгэн шилжүүлэх”, 41,000,000 төгрөгөөр хийгдэх “Жишиг хашаа” арга хэмжээний тендер зарлагдаж, урилга нийтлэгдсэн.

Байгаль хамгаалах зардлын 50,000,000 төгрөгөөр “Сумын нэгдсэн хогийн цэгийг Ландфиллын аргаар цэгцлэх” ажил бүрэн хийгдэж дууссан.





Нүдэн багийн “Нүдэнгийн булаг”-ийн хашааг эмхэлж цэгцэлсэн.



МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ